ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ДАА-2022/01/НА-СА-ТШЗ

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Дархан-Уул аймаг<br>2022 он | ҮАГ-ын дөрөвдүгээр газрын аудитын менежер: Л.Хонгорзул<br>Утас: 99090159<br>Аудитор: Ч.Гантулга<br>Утас: **9937-2297**<br>Цахим хаяг: GantulgaCh**@audit.gov.mn** |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2022.02.25 № 09/359

танай ________ -ны № ________ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.БАЯРНЯМ ТАНАА

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

101050403

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Я.САМБУУНЯМ

## Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

| | Үзүүлэлт | 2020.12.31 | 2021.12.31 |
|---|---|---|---|
| **Санхүүгийн байдлын тайлан** | | | |
| | Эргэлтийн хөрөнгийн дүн | **25,231,501,611.02** | **29,372,162,519.14** |
| | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | **1,750,493,709.76** | **1,716,877,988.72** |
| | **Нийт хөрөнгийн дүн** | **26,981,995,320.78** | **31,089,040,507.86** |
| | Нийт өр төлбөрийн дүн | **146,663,559.40** | **170,399,273.59** |
| | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн | **26,835,331,761.38** | **30,918,641,234.27** |
| | **Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **26,981,995,320.78** | **31,089,040,507.86** |
| **Санхүүгийн үр дүнгийн тайлан** | | | |
| | Үйл ажиллагааны орлогын дүн | **127,387,420,663.33** | **115,279,389,647.53** |
| | Үйл ажиллагааны зардлын дүн | **111,125,033,113.98** | **111,214,773,263.02** |
| | **Үйл ажиллагааны үр дүн** | **16,262,387,549.35** | **4,064,616,384.51** |
| | Үйл ажиллагааны бус үр дүн | - | 998,333.33 |
| | **Үйл ажиллагааны нийт үр дүн** | **16,262,387,549.35** | **4,065,614,717.84** |
| **Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан** | | | |
| | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 22,801,679.25 | 22,801,679.25 |
| | Тайлант оны үр дүн | **26,401,969,791.86** | **30,485,279,264.75** |
| | **Эцсийн үлдэгдэл** | **26,835,331,761.38** | **30,918,641,234.27** |
| **Мөнгөн гүйлгээний тайлан** | | | |
| | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн | **114,938,801,635.07** | **111,335,342,044.45** |
| | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн | **111,180,387,552.21** | **111,247,771,779.55** |
| | **Үйл ажиллагааны ЦМГ** | **3,758,414,082.86** | **87,570,264.90** |
| | **Хөрөнгө оруулалтын ЦМГ** | | |
| | **Санхүүгийн ажиллагааны ЦМГ** | | |
| | **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | **3,758,414,082.86** | **87,570,264.90** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 4,088,529,986.34 | 7,846,944,069.20 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 7,846,944,069.20 | 7,934,514,334.10 |
| **Төсвийн гүйцэтгэлийн тайлан** | | | |
| | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **93,575,348,900.00** | **92,411,371,499.43** |
| | Урсгал зардал | 93,575,348,900.00 | 92,411,371,499.43 |
| | Хөрөнгийн зардал | | |
| | **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **93,575,348,900.00** | **58,190,577,372.72** |
| | Улсын төсвөөс санхүүжих | 18,004,994,300.00 | 211,139,500.00 |
| | Нийгмийн даатгалын сангаас | 75,570,354,600.00 | 57,864,497,818.69 |
| | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | - | 114,940,054.03 |

**Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх зорилготойгоор 1 зорилт 3 чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Дөрөв. Аудитын гол асуудал**

Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад  үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

**Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Шилэн дансны мэдээлүүлбэл зохих 282 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

**Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

**Долоо. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 2,259.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд  1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар залруулсан алдаа гараагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлыг харуулав. Үүнд:

1. Зардал

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тус байгууллага 2021 онд цалин, хөлс, нэмэгдэл урамшлын зардлаас аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/200 дугаар захирамжаар байгууллагын дарга Н.Мөнхбаярыг 1 сарын үндсэн цалингийн 80 хувь буюу 870.9 мянга, хэлтсийн даргын 2021 оны А/24 дүгээр тушаалаар 3 ажилтанд 888.5 мянга, А/47 дугаар тушаалаар 2 ажилтанд 500.0 мянган төгрөгийн мөнгөн шагналыг тус тус олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 онд баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 5 дугаар тушаалын “Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлын ангилалд ажиллагсдын цалин, хөлс болон

хуулиар нийгмийн даатгалын шимтгэл бодогдох нэмэгдэл урамшлын зардлууд хамаарна ....", Сангийн сайдын 2021 онд баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

1.2 <u>*Өгсөн зөвлөмж:*</u>

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаал, Сангийн сайдын 2021 онд баталсан "Эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг мөрдөж, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх

## 7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

## 7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

| № | Төсвийн захирагчийн ангилал | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ТШЗ | 1 | 2.3 | | | | | | | 1 | 2.3 |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | ЗГТС | | | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | | | |
| | Дүн | 1 | 2.3 | | | | | | | 1 | 2.3 |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | ТШЗ | | | | | | | | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | | | | | | | | | | |
| 3 | ЗГТС | | | | | | | | | | |
| 4 | ТТЗ | | | | | | | | | | |
| 5 | ТЕЗ | | | | | | | | | | |
| | Дүн | | | | | | | | | | |
| | **НИЙТ ДҮН** | **1** | **2.3** | | | | | | | **1** | **2.3** |